

ГАРААНЫ БИЗНЕС ЭРХЭЛЭЖ БҮЙ ХҮН БҮРТ ХҮРГЭХ 7 ЗӨВЛӨГӨӨ

- 1. ХҮСЭЛ СОНИРХЛОО ХЭЗЭЭ Ч БҮҮ ОРХИЛДУУЛ**
/Ямар ч төрлийн гарааны бизнесийг эхлүүлэхэд тухайн хүний хүсэл сонирхол ихээхэн түлхэц үзүүлдэг. Харин нэгэнт гарааны бизнес эхлүүлээд бизнесийн стратеги боловсруулаад түүний дагуу явахаар ихэнх хүний хүсэл сонирхол нь тодорхой болдог/
- 2. БИЗНЕСИЙН МОДЕЛИЙГ САЙН СУДЛАХ НЬ ЧУУХАЛ**
/Бизнес эхлэнэ гэдэг нь урлаг болон шинжлэх ухаантай салшгүй холбоотой. Таны хүсэл мөрөөдөл бол урлаг, харин таны бизнесийн модель бол шинжлэх ухаан л гэсэн үг. Тиймээс өөрийн эрхэлж буй бизнесийн моделийг сайтар ойлгох нь чухал/
- 3. ХҮНИЙ НӨӨЦӨӨ БҮРДҮҮЛЭХДЭЭ УХААЛАГ БАЙ**
/Өөрийн багийг бүрдүүлэх нь сэтгэл хөдөлгөсөн зүйл хэдий ч мөн хариуцлагатай ажил юм. Чаддаг хүнээр нь чаддаг зүйлийг нь хийлгэ, нөгөө талаар өөрийнхөө хийх дургүй зүйлийг хийх дуртай хэн нэгнийг хөлслөх нь багийн амжилтын үндэс болдог/
- 4. ЭРСДЭЛИЙГ ҮҮРЭГЧ БАЙХ ХЭРЭГТЭЙ**
/Нөхцөл байдал яаж ч эргэж болно. Муу зүйл тохиолдход тэнцвэрээ алдахгүй байх хэрэгтэй. Эрсдэлээс өөрийгөө хамгаалж эрсдэлийг үүрэгч байх нь амжилттай стартапыг бий болгоход тустай/
- 5. ТАНЫ САНХҮҮ ХҮРЭЛЦЭХГҮЙ БАЙЖ БОЛНО. ГЭХДЭЭ ...**
/Та ганцаараа биш. Маш олон бизнес эрхлэгчид мөнгөний асуудалтай тулгардаг. Тиймээс өөрийн санааг хэрэгжүүлэхэд шаардлагатай тусламжийг бусдаас гуйхаасаа бүү санаа зов. Бүх хүмүүс бизнес эхлүүлэх зоригтой биш хэдий ч ихэнх бизнесийн эзэд нэгэнт эхлүүлсэн санааг дэмжээд хамтарч ажиллах дуртай байдаг/
- 6. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭЭ СОНГОХДОО АНХААР**
/Дөнгөж эхэлж буй бизнесийг сонирхох хүн цөөн гэж та бодож магадгүй ч хамаагүй хямд үнэ санал болгож буй үйлчлүүлэгчидтэй холбоо тогтоохгүй байсан нь дээр/
- 7. ДУУ ХООЛОЙГОО БУСДАД ХҮРГЭ**
/Өөрийн ямар бизнес эхлүүлээд яаж ажиллаж буйг бусдад мэдээлэх нь нэн чухал. Олон нийтийг хамарсан хурал цуглаанд оролцож мөн болгож олдох бүрд Засгийн газарт стартап компаниудыг дэмжиж, шинэ санааг саадгүйгээр хэрэгжүүлэх болгож олгохыг санал болгоорой/



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ
ГАЗАР**



НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙН ГАЗАР

**ЗАЛУУЧУУДЫН
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ,
ГАРААНЫ БИЗНЕСИЙГ
ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР**

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР

ЭРХЛЭЛТИЙН ГАЗАР, СОЁЛЫН ТӨВ

ӨРГӨӨ Г КОРПУС 5 ДАВХАР

11 329752

7011 0502 | 7012 0502

7013 0502 | 7014 0502

ЗОРИЛГО:

Залуучууд болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийг аж ахуй, бизнес эрхлэх ур чадвар, шинэлэг санаанд тулгуурлан гарааны болон санхүүгийн дэмжлэг олгох, бизнесээ тогтвортой эрхлэхийг дэмжих арга хэмжээнд хамруулж байнгын ажлын байртай болгох

ХАМРАХ ХҮРЭЭ:

15-34 насны залуучууд
15-24 насны Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчид
Сургалтын байгууллагууд
Бизнес инкубатор төвүүд

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ:

- ▶ Залуучуудын гарааны бизнесийг дэмжих
- ▶ Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгч болон төгсөгчдийн бүлэгт санхүүгийн дэмжлэг олгох /Эргэн төлөлтийн хугацаа 24 сар байна/
- ▶ Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгч болон төгсөгчдийн бүлэгт ажлын байрны түрээсийн хөнгөлөлт үзүүлэх
- ▶ Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгч болон төгсөгчдийн бүлгийн гишүүдэд аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах

ЗАЛУУЧУУДЫН ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ

- ▶ Гарааны бизнес эрхлэх бүлгийн гишүүдэд гарааны бизнесийн таатай орчин бүрдүүлэх, аж ахуй эрхлэх бизнес загвар боловсруулах сэтгэлгээний сургалт зохион байгуулна
- ▶ Гарааны бизнесийн санааг баяжуулах, өрсөлдүүлэх, багаар ажиглаж ирээдүйтэй санааг бизнесийн зөвлөхийн тусламжтайгаар хөгжүүлэх, шилдэг гарааны бизнесийн төслийг сонгон шалгаруулж эхний байранд шалгарсан төсөлд 10.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгоно.
- ▶ Санхүүгийн дэмжлэгийг 24 сарын дотор 100 хувь эргүүлэн төлнө.

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨГСӨГЧ БОЛОН ТӨГСӨГЧДИЙН БҮЛЭГТ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ

- ▶ Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчийг хувиараа болон бүлгээр хөдөлмөр эрхэлж, ажлын байр бий болгох зорилгоор тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авахад нь зориулж, нэг төгсөгчид 3.0 сая хүртэл төррөл, бүлэгт 10.0 сая хүртэл төгрөгийг эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгоно. Төгсөгчдийн бүлэг болсон тохиолдолд 5-аас ихгүй гишүүнтэй байна.
- ▶ Санхүүгийн дэмжлэгийг 24 сарын дотор 100 хувь эргүүлэн төлнө.

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨГСӨГЧ БОЛОН ТӨГСӨГЧДИЙН БҮЛЭГТ БОРЛУУЛАГТЫН БОЛОН АЖЛЫН БАЙРНЫ ТҮРЭЭСИЙН ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ

- ▶ Эргэн төлөгдөх санхүүгийн болон гарааны дэмжлэг авсан залуучууд, залуучуудын бүлгийн бараа, бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлэх, ажлын байрны түрээсийн хөнгөлөлт үзүүлнэ.
- ▶ Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар 6 болон түүнээс дээш сарын хугацаагаар байнгын ажлын байр түрээслэн үйл ажиллагаа явуулж байгаа бол түрээсийн гэрээ, холбогдох баримт бичиг, нөхцөл байдлыг газар дээр нь үнэлсэн үнэлгээнд үндэслэн ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг төлбөр төлсөн баримтаар нөхөн олгоно.
- ▶ Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдаж буй төгсөгч болон төгсөгчдийн бүлэгт аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгнө.

ГАРААНЫ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ГАРГАДАГ 10 АЛДАА

1. ГАНЦААРАД БҮХНИЙГ ХИЙГ ГЭЖ ОРОЛДОХ
2. БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАХТИ БАИХ
3. МӨНГӨӨ БҮРҮҮ ЗАРЦУУЛАХ
4. ӨӨР ТӨЛӨВЛӨГӨӨГИЙ БАИХ
5. ХЭТ ЖИЖИГ БОДОХ
6. БАЙРШЛАА БҮРҮҮ СОНГОХ
7. ЗӨН СӨВИНДОО ИТГЭХТИ БАЙХ
8. БИЗНЕС ЭРХЛЭГЧИД ЦАГ НЬ БОЛООГИ БАЙХАД ЯАРАН БИЗНЕСТ ОРОХ
9. АЖИЛД АВАХ ПРОЦЕСС БҮРҮҮ БАЙХ
10. ГАДНЫ НӨЛӨӨНД АВАТХ